



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Шүүхийн тамгын газар 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2020/125/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2020 он</p>	<p>Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70342580 Цахим хаяг: Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Ахлах аудитор: П.Мөнхтуяа Утас: 70342716 Цахим хаяг:</p>
--------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..	Error! Bookmark not defined.
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
Менежментийн захидал.....	Error! Bookmark not defined.
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	10
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	10
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	10
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	12
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	20


**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2020. 08. 08 № 35

танай _____ -ны № _____ т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Булган аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Булган аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Булган аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй

006020065

нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР



2.1. Оршил

Шүүхийн тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга П.Хишигдаваа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүхийн тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 07-ноос 2020 оны 02 дугаар сарын 08-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 08-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Мөнхтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Шүүхийн тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 31 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Булган аймаг дахь Шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Шүүн таслах үйл ажиллагааг тасралтгүй явагдах нөхцөлийг бүрдүүлж, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг байдлыг хангаж, шүүхийн захиргааны ажилтнуудын хөгжлийг дэмжиж ажиллахад оршино.

Зорилтыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Шүүхийн мэдээлэл, технологийн найдвартай ажиллагааг хангаж, шаардлагатай тоног төхөөрөмжийн шинэчлэлтийг үе шаттай хийх
- Шүүх шүүгчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг төлөвлөгөөний дагуу зохион байгуулах
- Шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудын ажиллах нөхцөлийг сайжруулж, үйлчлүүлэгчдэд аятай орчин бүрдүүлэх
- Шүүхийн захиргааны ажилтнуудын мэргэжлийн болон харилцаа хандлага, бие бялдрыг хөгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах
- Төсөв санхүүгийн нээлттэй, ил тод удирдлагыг хэрэгжүүлж, сахилга хариуцлагыг нэмэгдүүлж ажиллах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна

Шүүхийн тамгын газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд программ хангамж ашигладаг байна.

Шүүхийн тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Шүүхийн тамгын газрын 2019 оны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 7 эрсдэлтэй асуудалд 7 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн /жилийн эцсийн/ санхүүгийн тайлангийн материаллаг байдлыг сонгож, эрсдэлийн түвшинд “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 458237.2 мянган төгрөгөөс тооцон 9164.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинд 997091.4 мянган төгрөгөөр тооцсон нь нийт хөрөнгө орлогоос нийт зардал их учир нийт зардлын 2 хувиар сонгон авч үзсэн.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Шүүхийн тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 44621.9 мянган төгрөгөөр буюу 5.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	13149.1	13088.2	60.9
Үндсэн хөрөнгө	782525.6	737964.6	44561
Нийт хөрөнгө	795674.7	751052.8	44621.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	795674.7	751052.8	44621.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	795674.7	751052.8	44621.9

Авлага дансны үлдэгдэл өссөн /буурсан/ нь үзүүлэлт байхгүй болно.

Бараа материалын дансны үлдэгдэл 60.9 мянган төгрөгөөр өссөн /буурсан/ нь 61570.1 мянган төгрөгийн орлого авч 61631.0 мянган төгрөгийн зарцуулалт хийгдэж өсөлт бууралтын үзүүлэлтэй гарсан байна.

Энэ нь түлш шатахуун, аж ахуйн материал, бичиг хэргийн зардлууд эзэлж байна.

Оны эцэст 13088.2 мянган төгрөгийн шатахуун, бичиг хэрэг, аж ахуйн материалын үлдэгдэлтэй байгаа нь байгууллагын хэрэгцээнд шаардлагатай материалын үлдэгдэл гэж үзэж байна.

Бараа материалын дансанд 2019 оны байдлаар ШЕЗ-өөс шилжүүлсэн 594.6 мянган төгрөгийн бичиг хэрэг болон аж хуйн материалыг орлогод авч тайлагнажээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 44561.0 мянган төгрөгийн өсөлт бууралт нь тухайн онд 13733.4 мянган төгрөгийн орлого авч, 22630.8 мянган төгрөгийн хөрөнгийг ТӨБЗГ-ын 2019 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн А-1/3232 тоот албан бичгийн дагуу акталж тайлагнасан байна.

ШЕЗ-өөс 5170.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө шилжүүлснийг орлогод авч тайлагнаж шилжүүлсэн хөрөнгөөс акталж утгасан хөрөнгө гараагүй болно.

Биет бус хөрөнгийн 27264.0 мянган төгрөгийн үлдэгдэл дээр өссөн буурсан үзүүлэлт гаргаагүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлгүй тайлагнаж ажиллажээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 751052.8 мянган төгрөг болж 44621.9 мянган төгрөгөөр өссөн /буурсан/ нь бараа материал болон үндсэн хөрөнгийн зарцуулалт акталж устгасантай холбогдуулан үзэж байна.

Энэ нь тухайн жилд зарцуулсан материал, хөрөнгийн хөдөлгөөний үзүүлэлт юм.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 174.9 мянган төгрөгийн бичилт нь өмнөх оны өр авлагыг тайланд тусгаагүйгээс үүсэн гарч энэ жилийн санхүүгийн тайланд өөрчлөлт оруулан тайлагнасан байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Шүүхийн тамгын газрын санхүүгийн тайлант онд өөрийн орлогын төлөвлөгөө төлөвлөөгүй болно.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 944683.4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 29200.0 мянган төгрөгийг урсгал зардалд, 9000.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 906483.3 мянган төгрөгийг зарцуулахаар тус тус батлагджээ.

Нийт зардлын 944683.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 1850.0 мянган төгрөгийг ЗДН-өөс, 160.8 мянган төгрөгийг нөхөн төлбөрөөс оруулсан орлогыг тус тус бүртгэн санхүүжилтээр тайлагнасан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан товч тайлбарлах. /материаллаг дүнтэй хэлбэлзэл бүхий орлогын нэр төрөл, шалтгаан/

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан үзэхэд батлагдсан төсвийн дагуу зарцуулсан ч зарим нэг төсвийг зардал хооронд шилжүүлэн зарцуулжээ. Үүнд: Бичиг хэргийн зардлын 139.5 мянган төгрөгийг шуудан холбооны зардалд, тээвэр шатахууны зардлаас 135.8 мянган төгрөгийг бичиг хэргийн зардалд, тээвэр шатахууны зардлын 237.9 мянган төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх зардалд, урсгал зардлын 107.3 мянган төгрөгийг багаж техник хэрэглэлийн зардлаас тус тус шилжүүлэн зарцуулсан байна.

ЗДНөөц хөрөнгөөс 1850.0 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 1850.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 933393.5 мянган төгрөг буюу 98.5 хувьтай байгаа нь төлөвлөсөн зардлыг батлагдсан зардлын дагуу зарцуулж ажилласан байна.

Нэмэлт төсөв: Засгийн газрын нөөц сангаас 1850.0, нөхөн төлбөрийн орлого 160.8 буюу нийт 2010.8 мянган төгрөг орлогын санхүүжилт авч гүйцэтгэлээр бүрэн зарцуулж ажиллажээ.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 7 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 7 эрсдэл тодорхойлж нийт 7 горим сорил хэрэгжүүллээ. Сонгосон горим сорилоор алдаа зөрчил илрээгүй болно.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Шүүхийн тамгын газар нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласныг нийцлийн аудитаар авч үзэх болно.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1334.7 мянган төгрөгийн зөрчилд 1140.0 төлбөрийн акт тогтоосноос төлбөрийн актыг бүрэн барагдуулсан, 194.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмжийг бүрэн арилгаж зөвлөмжийн дагуу ажиллажээ.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Шүүхийн тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Шүүхийн тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ШТГ

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>13,149,115.00</u>	<u>13,088,245.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	13,149,115.00	13,088,245.00
354	Хангамжийн материал	13,149,115.00	13,088,245.00
35410	Бичиг хэргийн материал	1,940,040.00	1,803,700.00
35420	Аж ахуйн материал	11,209,075.00	10,510,545.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	774,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>782,525,581.59</u>	<u>737,964,612.75</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	782,525,581.59	737,964,612.75
392	Биет хөрөнгө	755,027,831.56	710,521,862.68
39201	Барилга, байгууламж, орон сууц	645,163,298.71	645,163,298.71
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-27,038,663.52
39203	Авто-тээврийн хэрэгсэл	116,100,000.00	116,100,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-76,172,222.33	-90,472,222.37
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	170,135,935.03	160,966,263.29
39206	Хуримтлагдсан элэгдэл	-138,444,709.34	-128,253,382.81
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	74,211,049.45	74,389,689.45
39208	Хуримтлагдсан элэгдэл	-52,293,216.42	-54,644,674.57
39214	Бусад үндсэн хөрөнгө	16,320,896.46	16,320,896.46
39215	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-2,109,801.96
39217	Ном	6,800.00	100,460.00
393	Биет бус хөрөнгө	27,497,750.03	27,442,750.07
39301	Программ хангамж	825,000.00	825,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-591,249.97	-646,249.93
39303	Бусад биет бус хөрөнгө	27,264,000.00	27,264,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>795,674,696.59</u>	<u>751,052,857.75</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>795,674,696.59</u>	<u>751,052,857.75</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	795,674,696.59	751,052,857.75
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	633,641,738.98	633,641,738.98
51101	Өмч: - төрийн	633,641,738.98	633,641,738.98
512	Хуримтлагдсан үр дүн	-135,709,244.21	-180,331,083.05
51210	Өмнөх үеийн үр дүн	-135,709,244.21	-135,884,211.57
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-44,446,871.48
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	297,742,201.82	297,742,201.82

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	795,674,696.59	751,052,857.75
---	--------------------------------------------------------	-----------------------	-----------------------

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ШТГ

/төгрөг/
СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	954,868,025.97	952,644,517.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	38,101,585.97	5,949,717.00
120	Нийтлэг татварын бус орлого	38,101,585.97	5,949,717.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	38,101,585.97	5,594,317.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	38,101,585.97	5,594,317.00
120009	Бусад орлого	00.00	355,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	916,766,440.00	946,694,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	906,666,000.00	944,684,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	906,666,000.00	944,684,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,100,440.00	2,010,800.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00	1,850,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	100,440.00	160,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	968,392,187.78	997,091,388.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	968,392,187.78	997,091,388.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	961,284,024.05	981,790,105.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	683,010,405.16	682,385,063.00
210101	Үндсэн цалин	543,014,481.16	535,563,329.00
210102	Нэмэгдэл	94,141,816.00	102,686,906.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,836,000.00	21,249,000.00
210104	Урамшуулал	23,018,108.00	22,885,828.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,517,644.84	85,351,383.03
210201	Тэтгэврийн даатгал	53,712,965.02	56,716,059.08
210202	Тэтгэмжийн даатгал	6,781,200.00	7,158,980.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,424,900.00	5,384,863.31
210204	Ажилгүйдлийн даатгал	1,356,200.00	1,774,115.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,242,379.82	14,317,365.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,970,298.00	54,096,585.00
210301	Гэрэл, цахилгаан	5,711,572.00	4,625,757.00

Шүүхийн тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210302	Түлш, халаалт	45,592,800.00	45,592,800.00
210303	Цэвэр, бохир ус	3,665,926.00	3,878,028.00
2104	Хангамж, бараа материалын зардал	56,968,945.89	53,409,740.46
210401	Бичиг хэрэг	20,018,914.00	17,122,190.00
210402	Тээвэр, шатахуун	13,582,900.00	15,211,775.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,688,948.89	8,252,625.46
210404	Ном, хэвлэл	407,000.00	170,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	90,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,271,183.00	12,563,150.00
2105	Норматив зардал	3,800,000.00	800,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,800,000.00	800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,546,766.00	27,660,912.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,102,800.00	371,900.00
210604	Урсгал засвар	11,443,966.00	27,289,012.00
2107	Томилолт, зочны зардал	9,263,200.00	8,242,400.00
210702	Дотоод албан томилолт	9,263,200.00	8,242,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,309,911.60	4,699,636.35
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,122,707.60	2,586,646.35
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	216,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	812,534.00	1,165,740.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	258,670.00	207,465.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	375,500.00
210807	Газрын төлбөр	72,000.00	82,285.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,896,852.56	65,144,385.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	103,000.00	1,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	5,350,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	53,793,852.56	58,294,385.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,108,163.73	15,301,282.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,692,416.00	2,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	2,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,415,747.73	13,301,282.80
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,415,747.73	13,301,282.80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-13,524,161.81</u>	<u>-44,446,871.48</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-70,541,275.81</u>	<u>-44,446,871.48</u>

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөг/

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	932,099,457.00	946,694,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	928,235,866.00	946,694,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	906,666,000.00	944,684,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	906,666,000.00	944,684,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,100,440.00	2,010,800.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00	1,850,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	100,440.00	160,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	916,402,267.00	938,131,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	916,402,267.00	938,131,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	897,824,677.27	922,830,217.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	678,116,022.91	682,385,063.00
210101	Үндсэн цалин	538,120,098.91	535,563,329.00
210102	Нэмэгдэл	94,141,816.00	102,686,906.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,836,000.00	21,249,000.00
210104	Урамшуулал	23,018,108.00	22,885,828.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,087,637.47	84,937,588.39
210201	Тэтгэврийн даатгал	52,282,957.65	56,302,264.44
210202	Тэтгэмжийн даатгал	6,781,200.00	7,158,980.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,424,900.00	5,384,863.31
210204	Ажилгүйдлийн даатгал	1,356,200.00	1,774,115.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,242,379.82	14,317,365.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,970,298.00	54,096,585.00
210301	Гэрэл, цахилгаан	5,711,572.00	4,625,757.00
210302	Түлш, халаалт	45,592,800.00	45,592,800.00
210303	Цэвэр, бохир ус	3,665,926.00	3,878,028.00
2104	Хангамж, бараа материалын зардал	49,176,838.89	51,031,382.46
210401	Бичиг хэрэг	14,991,233.00	16,391,250.00
210402	Тээвэр, шатахуун	13,582,900.00	16,389,537.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,825,665.89	8,252,625.46
210404	Ном, хэвлэл	398,100.00	170,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	90,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,378,940.00	9,737,970.00
2105	Норматив зардал	3,800,000.00	800,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,800,000.00	800,000.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,102,766.00	29,787,562.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,102,800.00	371,900.00
210604	Урсгал засвар	11,999,966.00	29,415,662.00
2107	Томилолт, зочны зардал	9,263,200.00	8,242,400.00
210702	Дотоод албан томилолт	9,263,200.00	8,242,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,244,323.00	4,699,636.35
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,057,119.00	2,586,646.35
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	216,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	812,534.00	1,165,740.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	258,670.00	207,465.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	375,500.00
210807	Газрын төлбөр	72,000.00	82,285.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,063,591.00	6,850,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,063,591.00	1,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	5,350,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,577,589.73	15,301,282.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,161,842.00	2,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	2,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,415,747.73	13,301,282.80
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,415,747.73	13,301,282.80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	15,697,190.00	8,563,300.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	15,697,190.00	8,563,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,697,190.00	8,563,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	15,697,190.00	8,563,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	15,697,190.00	8,563,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-15,697,190.00	-8,563,300.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
14	Бусад эх үүсвэр	00.00	00.00
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	00.00	00.00
145005	Дамжуулан зээлдүүлэх зээлээс эргэж төлөгдөх	00.00	00.00
145006	Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих	00.00	00.00
145007	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	00.00	00.00
145008	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	00.00	00.00
145009	Төрөл бүрийн хандив	00.00	00.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	00.00	00.00
230001	Эргэж төлөгдөх зээл	00.00	00.00

231001	Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих зээл	00.00	00.00
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	00.00	00.00
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	00.00	00.00
240001	Гадаад зээлийн үндсэн төлбөр	00.00	00.00
241001	Засгийн газрын бондын үндсэн төлбөр	00.00	00.00
242001	Засгийн газрын үнэт цаасны үндсэн төлбөр	00.00	00.00
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	00.00	00.00
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	00.00	00.00
250002	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	00.00	00.00
250003	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	00.00	00.00
250004	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	00.00	00.00
250005	Төлсөн ногдол ашиг	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

СТ-4А

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018оны 01-р сарын 1-нээрх үлдэгдэл	606,377,738.98	50,498,632.00	-70,470,931.24	586,405,439.74
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	5,302,962.84	5,302,962.84
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	606,377,738.98	50,498,632.00	-65,167,968.40	591,708,402.58
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00

C07	Тайлант үеийн үр дүн /цэвэр ашиг алдагдал/	27,264,000.00	00.00	-70,541,275.81	-43,277,275.81
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	633,641,738.98	297,742,201.82	-135,709,244.21	795,674,696.59
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	633,641,738.98	297,742,201.82	-135,709,244.21	795,674,696.59
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-174,967.36	-174,967.36
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	633,641,738.98	297,742,201.82	-135,884,211.57	795,499,729.23
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-44,446,871.48	-44,446,871.48
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	633,641,738.98	297,742,201.82	-180,331,083.05	751,052,857.75

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

ТГ

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	944,684,000.00	931,382,717.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	944,684,000.00	931,382,717.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	942,684,000.00	929,382,717.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	693,281,100.00	682,385,063.00
210101	Үндсэн цалин	561,863,900.00	535,563,329.00
210102	Нэмэгдэл	98,258,100.00	102,686,906.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,845,000.00	21,249,000.00
210104	Урамшуулал	13,314,100.00	22,885,828.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,510,100.00	84,937,588.39
210201	Тэтгэврийн даатгал	58,778,900.00	56,302,264.44
210202	Тэтгэмжийн даатгал	6,932,800.00	7,158,980.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,546,200.00	5,384,863.31

Шүүхийн тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210204	Ажилгүйдлийн даатгал	1,386,600.00	1,774,115.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,865,600.00	14,317,365.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,133,000.00	54,096,585.00
210301	Гэрэл, цахилгаан	4,625,800.00	4,625,757.00
210302	Түлш, халаалт	45,592,800.00	45,592,800.00
210303	Цэвэр, бохир ус	3,914,400.00	3,878,028.00
210304	Байрны түрээс	00.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	51,077,000.00	51,076,382.46
210401	Бичиг хэрэг	16,251,700.00	16,391,250.00
210402	Тээвэр, шатахуун	17,058,100.00	16,389,537.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,977,200.00	8,252,625.46
210404	Ном, хэвлэл	200,000.00	215,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	90,000.00	90,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,500,000.00	9,737,970.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	00.00
2105	Норматив зардал	800,000.00	800,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	00.00
210502	Хоол, хүнс	00.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,200,000.00	38,197,587.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,000,000.00	8,890,200.00
210602	Тавилга	00.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	00.00
210604	Урсгал засвар	29,200,000.00	29,307,387.00
2107	Томилолт, зочны зардал	8,284,300.00	8,242,400.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	8,284,300.00	8,242,400.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,398,500.00	4,647,111.35
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,210,600.00	2,586,646.35
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	216,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,162,000.00	1,162,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	325,900.00	207,465.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	75,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	375,500.00	375,500.00
210807	Газрын төлбөр	33,500.00	33,500.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	00.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	00.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5000000.00	5000000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,000,000.00	5,000,000.00
211	ХҮҮ	00.00	00.00
2111	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	00.00	00.00
211101	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	00.00	00.00

2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	00.00	00.00
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	00.00	00.00
212	ТАТААС	00.00	00.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	00.00	00.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	00.00	00.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	00.00	00.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	00.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2000000.00	2000000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	00.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	00.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	2,000,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	00.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	00.00	00.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	00.00
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	00.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	00.00
220001	Барилга байгууламж	00.00	00.00
221001	Их засвар	00.00	00.00
222001	Тоног төхөөрөмж	00.00	00.00
223001	Бусад хөрөнгө	00.00	00.00
224001	Стратегийн нөөц хөрөнгө	00.00	00.00
2260	Гадаад эх үүсвэрээр	00.00	00.00
226001	Гадаад эх үүсвэрээр	00.00	00.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	00.00	00.00
230001	Эргэж төлөгдөх зээл	00.00	00.00
231001	Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих зээл	00.00	00.00
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	00.00	00.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	944,684,000.00	931,382,717.20
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	944,684,000.00	931,382,717.20
131001	Улсын төсвөөс санхүүжих	944,684,000.00	931,382,717.20
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	00.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	00.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	00.00	00.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	00.00
132001	Орон нутгийн төсвөөс	00.00	00.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		

1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	00.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	00.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	00.00	00.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	00.00
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00
120004 3	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	00.00	00.00
120004 4	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	00.00	00.00
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	00.00	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	00.00	00.00
122002	Хандив тусламж /гадаад/	00.00	00.00
14	БУСАД ЭХ ҮҮСВЭР	00.00	00.00
145005	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	00.00	00.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	00.00	00.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	00.00	00.00
610001	Төсвийн байгууллага	00.00	00.00
610002	Төсвөөс гадуур байгууллага	00.00	00.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	37.00	35.00
620001	Удирдах ажилтан	05.00	05.00
620002	Гүйцэтгэх ажилтан	28.00	26.00
620003	Үйлчлэх ажилтан	04.00	04.00
620004	Гэрээт ажилтан	00.00	00.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	00.00	00.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	00.00	00.00
630001	Төрийн өмчит ЕБС	00.00	00.00
630002	Хувийн ЕБС	00.00	00.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	00.00	00.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	00.00	00.00
631002	Хувийн өмчит СӨБ байгууллага	00.00	00.00
632	МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ	00.00	00.00
632001	Төрийн өмчит МСҮТ	00.00	00.00
632002	Хувийн МСҮТ	00.00	00.00
64	ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО	00.00	00.00
640001	Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо	00.00	00.00

640002	Улсын эмнэлгийн амбулаториор эмчлүүлэгсдийн тоо	00.00	00.00
640003	Хувийн эмнэлгээр эмчлүүлэгсдийн тоо	00.00	00.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	37.00	35.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	15.00	15.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	12.00	10.00
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	00.00	00.00
650004	ССБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	00.00	00.00
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	00.00	00.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	00.00	00.00
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	00.00	00.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	00.00	00.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10.00	10.00
650010	Гэрээт ажилтан	00.00	00.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	00.00	00.00

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
ЗДНөөц сангаас	1850.0	1850.0
Нөхөн төлбөрийн орлого		160.8